

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНУУДАД
ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ
КОМИРНАТИ (Кух-мир-на-ти)
(КОВИД-19 ВАКЦИН, мРНХ)
(2023-2024 оны томьёо)**

Энэхүү хураангуй нь таныг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцах боломжийг хязгаарлахгүй болно. Хэрэв танд асууж лавлах зүйл байвал эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцана уу.

КОМИРНАТИ гэж юу вэ?

КОМИРНАТИ бол 12 ба түүнээс дээш насны хүмүүсийг КОВИД-19-өөс хамгаалах зорилгоор хэрэглэх вакцин юм.

КОМИРНАТИ вакцин нь хийлгэсэн бүх хүмүүсийг хамгаалахгүй байж магадгүй юм.

КОМИРНАТИ вакцин нь КОВИД-19 үүсгэгч SARS-CoV-2 вирус агуулаагүй. КОМИРНАТИ вакцин танд КОВИД-19 халдаах боломжгүй.

Хэн КОМИРНАТИ вакцин хийлгэх ёсгүй вэ?

Та дараах тохиолдолд КОМИРНАТИ вакцинд хамрагдаж болохгүй:

- КОМИРНАТИ эсвэл Пфайзер-Бионтек КОВИД-19 вакцины¹ өмнөх тунг хийлгэсний дараа хүнд хэлбэрийн харшлын урвал илэрсэн
- энэ вакцины аливаа бүрэлдэхүүн хэсэгт хүчтэй харшлын урвал илэрсэн (КОМИРНАТИ ямар найрлагатай вэ? хэсгийг үзнэ үү).

КОМИРНАТИ вакцин хийлгэхээсээ өмнө вакцины үйлчилгээ үзүүлэгчдээ дараах зүйлсийг оролцуулан эрүүл мэндийнхээ байдлын талаар мэдэгдэнэ үү:

- ямар нэгэн харшилтай эсэх
- КОВИД-19 вакцины өмнөх тунг хийлгэсний дараа хүнд хэлбэрийн харшлын урвал илэрсэн
- өмнө нь миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардит (зүрхний гаднах бүрхүүлийн үрэвсэл) зэрэг өвчнөөр өвдөж байсан эсэх
- халуурч байгаа эсэх
- цус алдалтын эмгэгтэй эсвэл цус шингэлэгч эм хэрэглэдэг
- дархлаа суларсан эсвэл таны дархлааны тогтолцоог өөрчлөх эм хэрэглэдэг
- жирэмсэн эсвэл жирэмслэх төлөвлөгөөтэй
- хөхүүл
- өөр ямар нэгэн КОВИД-19-ийн вакцин тариулсан
- тарилгаас шалтгаалан ухаан алдаж байсан

КОМИРНАТИ вакциныг хэрхэн тарьдаг вэ?

КОМИРНАТИ вакциныг булчинд тарилга хэлбэрээр хийнэ.

¹ КОМИРНАТИ (2023-2024 томьёо) вакциныг Пфайзер-Бионтек КОВИД-19 вакцин (анхны моновалент) болон Пфайзер-Бионтек КОВИД-19, Бивалент вакцинтай адил аргаар хийдэг боловч SARS-CoV-2 Омикрон хувилбарын ХВВ.1.5 баяжуулалтын уургийг кодолдог (Омикрон ХВВ.1.5).

КОМИРНАТИ вакцин ямар эрсдэлтэй вэ?

КОМИРНАТИ вакцин хүнд хэлбэрийн харшлын урвал үүсгэх магадлал багатай. Хүнд хэлбэрийн харшлын хүнд урвал нь вакцины тунг хийлгэсний дараа хэдэн минутаас нэг цагийн дотор илэрнэ. Энэ шалтгааны улмаас танд вакцин хариуцсан байгууллага таныг вакцин хийлгэсний дараа хяналт тавихын тулд тухайн газартаа хэсэг хугацаанд байх хүсэлт тавина. Хүнд хэлбэрийн харшлын урвалын шинж тэмдэг:

- Амьсгалахад хүндрэлтэй болох
- Нүүр, хоолой хавагнах
- Зүрх хурдан цохилох
- Биеийн бүх хэсэгт тууралт гарах
- Толгой эргэх, сульдах

КОМИРНАТИ болон Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцин зэрэг мРНХ КОВИД-19 вакцинуудыг хийлгэсэн зарим хүмүүс миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардитаар (зүрхний гаднах салст бүрхүүлийн үрэвсэл) өвдсөн. КОМИРНАТИ вакцины дараах миокардит, перикардит нь 12-17 насны өсвөр насны эрэгтэйчүүдэд ихэвчлэн тохиолдсон. Энэ хүмүүсийн ихэнхэд нь вакцин хийлгэснээс хойш хэд хоногийн дотор шинж тэмдэг илэрч эхэлсэн. Ийм тохиолдол үүсэх магадлал маш бага. Хэрэв та болон таны хүүхдэд вакцин хийлгэсний дараа, ялангуяа вакцины нэг тунг хийлгэснээс хойш 2 долоо хоногийн турш дараах шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл та яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Цээжээр өвдөх
- Амьсгал давчдах
- Зүрх хурдан, жигд бус, дэлсэх мэдрэмж төрөх

КОМИРНАТИ эсвэл Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцины сөрөг нөлөөг дараах байдлаар мэдээлсэн. Үүнд:

- Хүнд хэлбэрийн харшлын урвал
- Тууралт, загатналт, улайлт, чонон хөрвөс, нүүр хавагнах зэргийн хүнд бус харшлын урвалууд
- Миокардит (зүрхний булчингийн үрэвсэл)
- Перикардит (зүрхний гадна талын салст бүрхэвчийн үрэвсэл)
- Тарилгын хэсгийн хариу урвал: өвдөх, хавдах, улайх, гар өвдөх
- Ерөнхий гаж нөлөө: ядрах, толгой өвдөх, булчин өвдөх, жихүүдэс хүрэх, үе мөч өвдөх, халуурах, дотор муухайрах, бие тавгүйрхэх, тунгалагийн зангилаа хавдсан (лимфаденопати), хоолны дуршил буурах, гүйлгэх, бөөлжих, толгой эргэх
- Вакцин хийлгэсэнтэй холбоотойгоор ухаан алдах

Эдгээр нь КОМИРНАТИ вакцины бүх боломжит гаж нөлөө биш байж магадгүй юм. Танд хамааралтай гаж нөлөөний талаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчээсээ лавлана уу.

Вакцины гаж нөлөөг FDA/CDC Вакцины Сөрөг Нөлөө Мэдээллэх Тогтолцоонд (VAERS) мэдээллэнэ үү. ВСНМС-ийн 1-800-822-7967 үнэгүй утасны дугаар эсвэл <https://vaers.hhs.gov/reportevent.html> вебсайтад онлайн горимд мэдээлнэ үү.

Мөн та гаж нөлөөний талаар Pfizer Inc-д 1-800-438-1985 утсаар эсвэл www.pfizersafetyreporting.com вэбсайтад мэдэгдэх боломжтой.

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол яах вэ?

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ сонголтынхоо тухай ярилцаарай.

КОМИРНАТИ вакцин ямар найрлагатай вэ?

КОМИРНАТИ вакцин доорх найрлагатай:

- мессенжер рибонуклеины хүчил (mRNA)
- липидүүд ((4-гидроксибутил)азанедиил)бис(гексан-6,1-диил)бис(2-гексилдеcanoат), 2 [(полиэтиленены гликол)-2000]-N,N-дитетрадецилацетамид, 1,2-дистеароил-сн-глицеро-3-фосфохолин, ба холестерол)
- трометамин
- трометамин гидрохлорид
- сахароз

КОМИРНАТИ вакцин нөөшлөгч бодис агуулдаггүй.

Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан мэдээлэл шинэчлэгдсэн.

Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан хамгийн сүүлийн мэдээллийг <https://dailymed.nlm.nih.gov/dailymed/> вэбсайтаас авна уу.

Хэрэв танд асуулт байвал эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцах эсвэл www.COMIRNATY.com вэбсайтаас үзэх эсвэл 1-877-VAX-CO19 (1-877-829-2619) утас руу залгана уу.

BIONTECH

Үйлдвэрлэсэн

BioNTech Manufacturing GmbH

An der Goldgrube 12

55131 Mainz, Germany



Үйлдвэрлэсэн

Пфайзер Inc., Нью Йорк хот, NY 10001

LAB-1587-1.0

АНУ-ын засгийн газар Лицензийн № 229

Хянасан: 2023 оны 9-р сар